

САНХҮҮГИЙН
МЭДЭЭЛЛИЙН АЛБА

ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН ТУХАЙ ГАРЫН АВЛАГА

2022 ОН

Энэхүү гарын авлагыг харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны хүрээнд хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг тогтоох, баталгаажуулах, эцсийн өмчлөгчтэй холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлж байж болзошгүй шинж тэмдгүүдийг танихад дэмжлэг үзүүлэх зорилгоор мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулан олон улсын стандарт шаардлага, дотоодын хууль эрх зүйн орчинд нийцүүлэн боловсруулав.

Зөвшөөрөлгүй хэвлэн нийтлэх, тараахыг хориглоно.

©2022 Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба

Санхүүгийн мэдээллийн алба

Бага тойруу-3, 15160

Улаанбаатар-46, Монгол Улс

Утас: 976-11-326161, 976-11-321199

Факс: 976-11-311471

Е-mail: fiu@mongolbank.mn

Цахим хуудас: fiu.mongolbank.mn

АГУУЛГА

НЭГ. ОЛОН УЛСЫН СТАНДАРТ ШААРДЛАГА БА ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ.....	3
1.1. Оршил	3
1.2. Олон улсын стандарт шаардлага	4
1.3. Монгол Улсын хууль, эрх зүйн орчин.....	6
ХОЁР. ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ ТОГТООХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА...	9
2.1. Эцсийн өмчлөгчийг тогтоох нь яагаад чухал вэ?	9
2.2. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг ямар байдлаар нуун далдалдаг вэ?	9
ГУРАВ. ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ ТОГТООХ НЬ	11
3.1. Компанийн эцсийн өмчлөгчийг тогтоох нь	13
3.2. Компаниас бусад хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тогтоох нь....	17
3.3. Өөр хүний өмнөөс гүйлгээ хийж байгаа этгээдийн эцсийн өмчлөгчийг тогтоох нь	18
3.4. Улс төрд нөлөө бүхий этгээд болон бусад өндөр эрсдэлтэй харилцагч .	18
ДӨРӨВ. ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ БОЛОН БАТАЛГААЖУУЛАХ.....	19
4.1. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг тодорхойлох эсхүл баталгаажуулах боломжгүй тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээ	20
ТАВ. БУСАД	22
5.1. Бусад шаардлага.....	22
5.2. Хяналт шалгалт, зөрчилд тооцох хариуцлага	22
ЗУРГАА. ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧТЭЙ ХОЛБООТОЙ МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЖ БАЙЖ БОЛЗОШГҮЙ ШИНЖ ТЭМДГҮҮД.....	23
ДОЛОО. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	25
ХАВСРАЛТ	29

НЭГ. ОЛОН УЛСЫН СТАНДАРТ ШААРДЛАГА БА ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

1.1. Оршил

Санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас гаргасан олон улсын стандартад улс орнуудыг эцсийн өмчлөгчийн мэдээллийг цуглуулж, шаардлагатай тохиолдолд санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх бүхий байгууллагыг мэдээлэлд хандах боломжоор хангах шаардлагатай тухай тусгасан байдаг. Монгол Улс нь эдгээр стандартыг биелүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд тууштай хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээг шат дараатай авч байна.

Хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд нь төрөл бүрийн арилжаа, худалдаа, наймаа болон бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг. Хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн дэлхийн эдийн засагт оруулж байгаа хувь нэмэр, хууль ёсны үүрэг маш ач чухал ач холбогдолтой хэдий ч зарим тохиолдолд эдгээрийг мөнгө угаах, хээл хахууль, авлига, татвараас зайлсхийх, залилан, терроризмыг санхүүжүүлэх болон олон нийтэд ил болоогүй дотоод мэдээлэл ашиглах зэрэг хууль бус үйл ажиллагаанд дараах байдлаар:

- сэжигтэн болон гэмт хэрэгтэн,
- хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн эзэмшиж буй аливаа данс, эд хөрөнгийн бодит зориулалт,
- эзэмшиж буй аливаа данс, эд хөрөнгийн жинхэнэ зориулалт, эх үүсвэрийг өнгөлөн далдлах, нуухад зэрэгт ашиглаж байна.

Хууль ёсны өмчлөгч болон эцсийн өмчлөгчийн хөрөнгийн эх үүсвэр болон түүний үйл ажиллагааны талаарх мэдээллийг эрх бүхий байгууллагууд авах эрхтэй байвал хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг зүй бусаар ашиглах; харилцагч, үйлчлүүлэгчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлж, баталгаажуулах; харилцагч, үйлчлүүлэгчийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн түвшнийг тогтооход маш чухал ач холбогдолтой. Зарим гэмт хэрэгт холбогдсон аж ахуйн нэгжүүд өөрсдийн бизнес, хөрөнгийн эзэд болон эцсийн өмчлөгчийг зориудаар нуухыг оролддог. Зарим тохиолдолд харилцагч, үйлчлүүлэгчийн эцсийн өмчлөгчийг хэн болохыг олж тогтоох, баталгаажуулах нь маш ярвигтай, хэцүү үйл ажиллагаа байдаг. Энэ нь өмчлөлийн бүтэц хууль ёсны боловч нь өмчлөлийн бүтэц нарийн төвөгтэй байхтай холбоотой байж болно. Мөн энэ нь эцсийн өмчлөгчийг нуун дарагдуулах гэсэн оролдлого байж болзошгүй тул анхаарал, сэрэмжтэй байх хэрэгтэй.

Энэхүү гарын авлага нь хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн 33-аас дээш хувийг эзэмшдэг хувь хүн, харилцагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа болон

эцсийн өмчлөгч этгээдийг нэрийн өмнөөс гүйлгээ хийсэн этгээдийг хэрхэн тодорхойлох талаар мэдээлэл өгөх зорилготой.

Энэ гарын авлага нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд тусгасан мэдээлэх үүрэгтэй этгээдэд төдийгүй бусад байгууллагууд эцсийн өмчлөгчийг хэрхэн тогтоох талаар мөрдөх гарын авлага болно.

1.2. Олон улсын стандарт шаардлага



Санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ) нь улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээг тодорхойлдог. Үүний дагуу ФАТФ-ын Зөвлөмж 24 болон 25-д улс орнуудыг хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд зүй бусаар ашиглагдахаас сэргийлж эцсийн өмчлөгчийг тодорхойлон, мэдээллийн ил тод байдлыг хангах арга хэмжээг авахыг шаарддаг.

ФАТФ-ын Зөвлөмж 24: Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон ил тод байдал

ФАТФ-аас Зөвлөмж 24-ийг 2022 оны 3 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулан шинэчилсэн. Нэмэлт өөрчлөлтөөр улс орнуудыг эцсийн өмчлөгчийн мэдээллийг олон төрлийн аргачлалыг ашиглан цуглуулж, эрх бүхий байгууллагыг хүсэлтийн дагуу мэдээллээр цаг тухайд нь хангадаг байх шаардлагатай болохыг тусгасан. Түүнчлэн улс орнуудаас ФАТФ-ын Зөвлөмж 10, 22-ын дагуу санхүүгийн байгууллага, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нарыг харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ эцсийн өмчлөгчийн мэдээллийг цуглуулж, нягталсан байхыг шаарддаг.

Зөвлөмж 24-ийн ерөнхий шаардлагууд:

Хуулийн этгээдийг МУТС-тэй холбоотой зүй бусаар ашиглах эрсдэлийг үнэлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчтэй холбоотой үнэн зөв, бүрэн болон сүүлийн үеийн мэдээлэлтэй байх шаардлагатай.

Энэ мэдээллийг эрх бүхий байгууллагууд цаг алдалгүй, түргэн шуурхай, үр дүнтэй авч чаддаг байх ёстой.

Улс орнууд хуулийн этгээдийг эзэмшигчийн хувьцаа (bearer share) шинээр гаргах, эзэмшигчийн хувьцаа (bearer share)-ны баталгаа шинээр гаргахыг хориглох хэрэгтэй. Мөн одоо байгаа мэдүүлэгчийн хувьцаа, мэдүүлэгчийн хувьцааны баталгааг зүй бусаар ашиглахаас сэргийлэх хэрэгтэй.

Улс орнууд нэрлэсэн хувьцаа эзэмшигч (nominee shares), нэрлэсэн захирал (nominee director)-тай байхыг зөвшөөрдөг бол МУТС холбоотой зүй бусаар ашиглагдахаас сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай.

Зөвлөмж 10, 22-ын хүрээнд санхүүгийн байгууллага, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч (СББМҮҮ)-д эцсийн өмчлөгч болон өмчлөгчийн мэдээллийг авахад дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

Шигтгээ 1. Олон талт хандлагын арга /Multi-pronged approach/

ФАТФ-ын зөвлөмж 24 шинэчлэгдсэнээр улс орнууд эцсийн өмчлөгчийг тогтоохдоо олон талт хандлагын арга буюу бүртгэлийн, компанийн, боломжит мэдээллийн аргачлалыг хослуулан хэрэглэх шаардлагатай болсон. Доорх зургаар аргачлал тус бүрийг тайлбарлав.

Бүртгэлийн аргачлал

- Хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллагаас хуулийн этгээдийн эцсийн өмчлөлийн талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллийг авах, хадгалахыг шаарддаг
- Улс орнууд бүртгэлийн байгууллагатай дүйцэх өөр хувилбарыг эрх бүхий байгууллагууд мэдээллийг цаг алдалгүй, түргэн шуурхай, үр дүнтэйгээр олж авч чадаж байвал ашиглаж болно. Анхан шатны болон одоо байгаа мэдээллийг ашиглах нь хангалтгүй тул өөр тусдаа мэдээлэлд хандах арга, хэрэгсэлтэй байх шаардлагатай.

Компанийн аргачлал

- Компаниуд нь эцсийн өмчлөлийн талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллээ тогтоож, хадгалах арга хэмжээ авахыг шаардах

Нэмэлт мэдээллийн аргачлал

- Нэмэлт мэдээллийг дараах эх үүсвэрээс авч болно. Үүнд:
- Зөвлөмж 10,22-н дагуу Санхүүгийн байгууллага болон СББМҮҮ нарын цуглуулсан мэдээлэл
- Эрх бүхий байгууллагын хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл
- Хуулийн этгээдэд байгаа эцсийн өмчлөгчийн мэдээлэл
- Зохицуулагч байгууллага болон хөрөнгийн биржид байгаа мэдээлэл зэрэг орно.

Түүнчлэн ФАТФ-ын улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлдэг Шууд хэрэгжилтийн 5-д зааснаар үр дүнтэй тогтолцоо нь хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдахаас сэргийлж, тэдгээрийн эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг эрх бүхий байгууллагууд цаг алдалгүй, түргэн шуурхай, үр дүнтэйгээр авдаг байх ёстой.

Шууд хэрэгжилтийг үнэлэхэд үр дүнтэй тогтолцоо нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг гэмт хэрэгт ашиглагдахаас урьдчилан сэргийлсэн;
2. Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг хангалттай ил тод болгосон;
3. Өмчлөлийн болон эцсийн өмчлөгчийн талаарх үнэн зөв мэдээллийг цаг тухайд нь авдаг.

1.3.Монгол Улсын хууль, эрх зүйн орчин

Монгол Улсад хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэлийн байгууллага болон мэдээлэх үүрэгтэй этгээдүүд бүртгэж байна. Ингэхдээ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох журам, зааврын хүрээнд эцсийн өмчлөгчийн мэдээллийг тогтооно.

1.3.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д эцсийн өмчлөгчийг доорх байдлаар тодорхойлсон.

3.1.6.“эцсийн өмчлөгч” гэж:

3.1.6.а.харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

3.1.6.б.харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

3.1.6.в.хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

Мөн тус хуулийн 4¹ дүгээр зүйлд эцсийн өмчлөгчийг шалгаж тогтоох дарааллыг тусгасан. Үүнд:

1. хувьцааны дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг;
2. хувьцааны дийлэнх хэсгийг дангаараа эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж байгаа, эсхүл өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүнийг;
3. дээрх 2 аргаар хүнийг тогтоох боломжгүй бол хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлэгч хүнийг.

1.3.2. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмын 4 дүгээр хэсэгт эцсийн өмчлөгчийг тогтоох нарийвчилсан үйл ажиллагааг зохицуулсан заалтыг тусгасан. Тус журамд зааснаар мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг өөрийгөө эсхүл нэг болон түүнээс дээш эцсийн өмчлөгчийг төлөөлж байгаа эсэхийг тодорхойлж, эцсийн өмчлөгчийг таньж мэдэх шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь эцсийн өмчлөгчийг тогтоохдоо “дийлэнх хэсэг” гэдгийг шууд болон шууд бус хэлбэрээр нийт хувьцааны 33 хувийг өмчилж байгаа гэж ойлгоно.

Шууд болон шууд бус эцсийн өмчлөгч гэж хэн бэ?



Зургийн тайлбар: А компанийн хувьцааны 30 хувийг А хүн шууд, 70 хувийг В хүн шууд бусаар эзэмшиж байна.

Шууд бус өмчлөлийг тогтоохдоо:

- бүх төрлийн хуулийн этгээд эсхүл трастын гэрээ болон ижил төстэй гэрээ хэлцлээр эзэмшиж байгаа хувьцааны хувийг тэдгээрийн хувьцаа эзэмшигч эсхүл ашиг шимийг хүртэгч этгээд /бүлэг этгээдүүдийн/ хувьцаа гэж тооцно;

- гэр бүлийн нэг гишүүний эзэмшиж байгаа хувийг гэр бүлийн бусад гишүүдийн эзэмшиж байгаа хувьтай нэгтгэн авч үзнэ.

1.3.3. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль

Тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу банк, эрх бүхий хуулийн этгээд нь хуулийн этгээд, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээдэд данс нээхдээ эцсийн өмчлөгчийн талаарх мэдээллийг шаарддаг.

1.3.4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль

Тус хуулийн 3 дугаар бүлгийн 10 дугаар зүйлийн 10.1.14-т заасны дагуу хуулийн этгээдийн хувийн хэргийн мэдээлэлд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл багтдаг.

Түүнчлэн тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т зааснаар шинээр байгуулагдсан хуулийн этгээд нь улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл гаргахдаа хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

1.3.5. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөх журам

Улсын бүртгэлийн ерөнхий газрын улсын бүртгэгч нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд хөтлөхдөө:

Тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг /Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд заасан хувь хэмжээ буюу 33 хувийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа этгээдийг бүртгэдэг. Энэ аргаар эцсийн өмчлөгчийг тогтоох боломжгүй үед:

1. Хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж, тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг нь хүртэж байгаа этгээдийг;
2. Өөрийн эрхийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж, тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг нь хүртэж байгаа этгээдийг;
3. Дээрх 1, 2-т заасан аргаар эцсийн өмчлөгчийг тогтоох боломжгүй бол тухайн хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа этгээдийг бүртгэнэ.

Улсын бүртгэлийн ерөнхий газар нь дээр дурдсан хууль, журмын дагуу хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг УБ-12 маягтын дагуу бүртгэдэг.

ХОЁР. ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ ТОГТООХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

2.1. Эцсийн өмчлөгчийг тогтоох нь яагаад чухал вэ?

Эцсийн өмчлөгчийг нууцлах нь татвараас зайлсхийх, авлига, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт ашиглагдах боломжийг улам нэмэгдүүлдэг. Гэмт этгээдүүд хууль бусаар олж авсан эд хөрөнгөө нуун далдлах зорилгоор маш олон төрлийн арга, хэрэгсэл, техник технологи болон схем ашигладаг. Ийм схемийг бий болгож, өөрийн өмчлөлийн хуулийн этгээдийг хууль ёсны мэт харагдуулж, санхүүгийн системд гэмт хэргийн гаралтай “бохир” мөнгө оруулж, хөрөнгө мөнгийг угааж, цэвэршүүлэх ажиллагааг хийдэг байна. ФАТФ, Дэлхийн банк, НҮБ-ын Хар тамхи, зохион байгуулалттай тэмцэх газар зэрэг олон улсын байгууллагын хийсэн судалгаагаар хуулийн этгээдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хэрэгт зүй бусаар ашиглах явдал байсаар байгааг сануулж байна. Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн шаардлагатай, үнэн зөв мэдээллийг авч чадахгүй байгаа нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг үйлдэхэд дараах мэдээллийг нуун далдалж, дэмжлэг үзүүлж байна гэж үзэж болно. Үүнд:

- Бүртгэгдсэн, сэжиглэгдэж байгаа гэмт хэрэгтний мэдээлэл;
- Хуулийн этгээдийн эзэмшиж байгаа данс, эд хөрөнгийн бодит зорилго;
- Хуулийн этгээдтэй холбоотой эд, хөрөнгийн хэрэглээ, гарал үүсэл.

Хуулийн этгээдийн ашиг шимийг хүртэж байгаа этгээд нь гэмт этгээд эсхүл хориг арга хэмжээний жагсаалтад орсон этгээд байж болзошгүй. Иймд мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг явуулж, эцсийн өмчлөгчийг тогтоож, баталгаажуулах арга хэмжээг авсны дараа харилцагчид данс нээж, бизнес харилцаа үүсгэх, үйлчилгээ үзүүлэх зайлшгүй шаардлагатай байдаг. Ингэснээр мэдээлэх үүрэгтэй этгээд нь банк, санхүү, төлбөр тооцооны системийг хууль бус мөнгөн хөрөнгө, эх үүсвэрээс хамгаалахаас гадна өөрийн үйл ажиллагаа, бизнесийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад гэмт хэргээс ангид байлгаж, урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

2.2. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг ямар байдлаар нуун далдалдаг вэ?

ФАТФ-ын “Эцсийн өмчлөгч, түүний ил тод байдал” зөвлөмжид дурдсанаар эцсийн өмчлөгчийн мэдээллийг дараах аргуудаар ихэвчлэн нуун далдалдаг. Үүнд:

- Халхавч компани (хууль бус үйл ажиллагаа болон орлогын эх үүсвэрийг хууль ёсны бизнесийн үйл ажиллагаагаар өнгөлөн далдалсан компани, мөн хэд хэдэн улс орон дамнасан бүтэцтэй, гадаад улсын өмчлөлтэй байх нь элбэг байдаг);

- Нарийн төвөгтэй өмчлөл, удирдлагын тогтолцоо: гинжин хэлхээ бүхий үргэлжилсэн өмчлөл, хувьцаа эзэмшигчийн бүтэцтэй;
- Эзэмшигчийн хувьцаа (bearer share) болон эзэмшигчийн хувьцааны баталгаа (bearer share warrant): Зарим тохиолдолд компанийн жинхэнэ эцсийн өмчлөгч, хөрөнгийн жинхэнэ эзэмшигчийг нуун далдлахад эзэмшигчийн хувьцааг ашигладаг. Эзэмшигчийн хувьцааг бусдад шилжүүлэх, дамжуулахад амархан байдаг тул харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны үед хувьцаа эзэмшигчээр тогтоогдсон этгээд богино хугацааны дотор удаа дараа өөрчлөгдөх магадлалтай;
- Хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, захирлын эрх хэмжээнд хязгаар тогтоохгүй байх;
- Албан ёсны нэрлэсэн хувьцаа эзэмшигч болон нэрлэсэн удирдлагатай хуулийн этгээд (nominee shareholder and directors): Зарим улс оронд компанийн хувьцааг нэрлэсэн буюу төлөөлөл бүхий этгээдийн нэр дээр эзэмшүүлэх болон нэрлэсэн буюу төлөөлөл бүхий удирдлагатай байх боломжийг хуулиар зөвшөөрсөн байдаг. Хуулийн этгээдийн энэхүү нэрлэсэн эзэмшигч эсхүл удирдлага нь жинхэнэ эцсийн өмчлөгч, удирдлага нь биш байдаг бөгөөд эцсийн өмчлөгчийн нэрийг нийтэд ил гаргахгүй, нуун далдлах зорилгоор тэдний ойр дотнын, гэр бүлийн гишүүд гэх мэт төлөөлж байгаа хувь хүмүүс байдаг;
- Траст болон үүнтэй төстэй бусад хуулийн зохицуулалт бүхий этгээд: Эдгээр хэлбэр нь хөрөнгийн хууль ёсны эцсийн өмчлөгчийг тусгаарлах, өөр этгээдэд өмчлөлийн эрхийг олгох боломжийг бий болгодог;
- Хуулийн этгээдийг байгуулах болон үйл ажиллагааг эрхлэх компани зуучлалын үйлчилгээг ашиглах: хуульч, мэргэжлийн зуучлалын үйлчилгээ гэх мэт.

Гэмт этгээдүүд нь дээр дурдсан арга замыг ашиглан хуулийн этгээдийг байгуулж, удирдан хянаж, үйл ажиллагаанд нь нөлөөлөн зохион байгуулж гэмт үйлдэл, өөрийгөө болон гэмт хэргийн бүлгээ нуун далдлах замаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг үйлддэг байна. Энэ нь хууль сахиулах байгууллагууд төдийгүй мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд ихээхэн төвөг учруулдаг байна.

Иймд санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нар нь хууль, журамд заасан шаардлагын дагуу хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэн, баталгаажуулдаг байх шаардлагатай.

ГУРАВ. ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ ТОГТООХ НЬ

Эцсийн өмчлөгч гэж:

- a) гүйлгээ хийсэн хуулийн этгээд болон хувь хүний үйл ажиллагааг удирдан чиглүүлж байгаа хувь хүнийг
- b) хуулийн этгээдийн 33 хувиас дээш хувийг өмчилж байгаа хувь хүнийг хэлнэ.

Таны үүрэг бол эцсийн өмчлөгч (үүд) болох хувь хүн (хүмүүс)-ийг тодорхойлох явдал юм. Эцсийн өмчлөгч нь зөвхөн хувь хүн байх бөгөөд компани, хуулийн этгээд байх боломжгүй. Нэг үйлчлүүлэгчтэй холбоотой нэгээс олон эцсийн өмчлөгч байж болно. Таны үүрэг бол үйлчлүүлэгчийнхээ бүх эцсийн өмчлөгчийг хэн болохыг олж тогтоох, баталгаажуулах явдал юм.

Хэрэв таны харилцагч хувь хүн бол Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6.б хэсэгт зааснаар тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг эцсийн өмчлөгчөөр тооцох хэрэгтэй. Хэрэв харилцагч өөр хүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа бол та тухайн хүнийг тодорхойлох мэдээллийг, эцсийн өмчлөгчийн мэдээлэлтэй хамт тодорхойлох шаардлагатай.

Гадаад улсын болон дотоодын хуулийн этгээдийн төрөл, хэлбэрүүд дараах хэлбэртэй байж болдог. Үүнд:

- Компани: Хязгаарлагдмал хариуцлагатай компани (хувьцаа, баталгаагаар хязгаарлагдсан); Бүрэн хариуцлагатай компани, Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани, Нээлттэй хувьцаат компани, Хаалттай хувьцаат компани, Оффшор бүсэд бүртгэлтэй компани;
- Холбоо;
- Хоршоо;
- Сан;
- Нөхөрлөл;
- Төрийн бус байгууллага;
- Эрх зүйн бусад зохицуулалт: Ашиг шимийг хүртэгч этгээдүүдэд ирээдүйд үүсэх эрхийн хэмжээг бүрэн тодорхойлсон Траст хэлцэл (discretionary trust) нэг этгээдээс нөгөө этгээдэд хөрөнгө шилжүүлэх Траст хэлцэл (express trusts).

Харилцагч нь дээр дурдсан хуулийн этгээдийн төрөл хэлбэрээс гадна Монгол Улсын хуулиар зохицуулаагүй, мэдээлэх үүрэгтэй этгээдэд ойлгомжгүй, эсвэл шинэ хэлбэртэй гадаад дотоодын хуулийн этгээд байх боломжтой учраас мэдээлэх үүрэгтэй этгээд нь

хамгийн багадаа эдгээр хуулийн этгээдээс үүсэж болох эрсдэлийг ойлгож, удирддаг байх ёстой.

Түүнчлэн мэдээлэх үүрэгтэй этгээд нь дээр дурдсанаас бусад хуулийн этгээдтэй бизнесийн аливаа харилцаа тогтоохдоо харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тодорхойлох боломжит бүх арга хэмжээг авч, шаардлагатай тохиолдолд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, бизнес харилцаагаа цуцлах болон данс хаах хүртэл арга хэмжээг авбал зохино.

Эцсийн өмчлөгчийг тогтоохдоо дараах шалгуурын дагуу тогтооно. Үүнд:

1. Хуулийн этгээдийн хувьцааны 33%-аас доошгүй хувийг шууд болон шууд бусаар, бусадтай хамтран эзэмшигчийг.
2. Тухайн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэгч хувь хүнийг.
3. Аливаа этгээдийн нэрийн өмнөөс төлөөлөн гүйлгээ хийж байгаа бол төлөөлүүлэгч хувь хүнийг шалгаж, тодорхойлох.

Мэдээлэх үүрэгтэй этгээдийн зүгээс дээр дурдсан шалгуурын аль нэг (эсвэл хослол) хангагдаж байна гэж үзвэл ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ гэж үзэж болно.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны дагуу эцсийн өмчлөгчийг тогтоохдоо хамгийн багадаа доор дурдсан шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд тухайлбал:

- a) Харилцагчаас эцсийн өмчлөгчийн мэдээллийг нь тодорхойлуулж авах;
- b) Харилцагчийн өгсөн мэдээллийн дагуу холбогдох бичиг баримтыг гаргуулан авах;
- c) Харилцагчийн өгсөн мэдээлэл, түүнд холбогдох бичиг баримтын үнэн зөвийг албан ёсны мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан баталгаажуулан шалгах /улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн сангаас баталгаажуулах г.м./

Мэдээлэх үүрэгтэй этгээдийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох үйл ажиллагаа нь дээр дурдсан 3 арга хэмжээгээр хязгаарлагдахгүй болно. Түүнчлэн дээрх дарааллаас ii болон iii дах арга хэмжээг эрсдэлд суурилсан аргачлалаар хэрэгжүүлэх бөгөөд үүгээр хязгаарлахгүйгээр эцсийн өмчлөгчийг тогтоох, хянан баталгаажуулахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг дотоод бодлого, журамдаа тусган хэрэгжүүлнэ. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь эцсийн өмчлөгчийг тогтоох боломжит бүхий л арга хэмжээг авсны үр дүнд учирч болох эрсдэлийг удирдан бууруулах боломжтой гэж үзсэн үед эцсийн өмчлөгчийг тогтоох ажиллагааг зогсоож болно.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь эрсдэлд суурилсан аргачлалын дагуу үнэлгээ хийж, өндөр эрсдэлтэй харилцагчийн хувьд 33 хувиас бага хувийг эзэмшиж байгаа этгээдийг эцсийн

өмчлөгчөөр тодорхойлох боломжтой юм. Энэ талаар дотоод бодлого журамдаа тодорхой тусгасан байх шаардлагатай.


Түүнчлэн харилцагчийн үйл ажиллагааг шууд бусаар удирдан чиглүүлж байгаа боловч хувьцаа эзэмшдэггүй этгээд байх боломжтой. Энэ тохиолдолд эрсдэлд суурилсан аргачлалаар боломжит байдлаар тодорхой үндэслэл шалтгааныг тогтоон, тухайн этгээдийг эцсийн өмчлөгч гэж үзэж болно. Тухайлбал, хувьцаа эзэмшигч этгээдийн гэр бүлийн хүн зэрэг хамаарал бүхий этгээд эсхүл гэрээний дагуу хамтран ажилладаг этгээд эсхүл нэгдмэл сонирхолтой бусад этгээд хуулийн этгээдийг шууд бусаар удирдаж, ашиг шимийг хүртэгч эцсийн өмчлөгч байх магадлалтай.

Байгууллагын төрөл, хэлбэр, цар хүрээ, бүтэц, зохион байгуулалтыг үл харгалзан аливаа хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг хувь хүн хүртэл нь тодорхойлно.

3.1.Компанийн эцсийн өмчлөгчийг тогтоох нь

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь юун түрүүнд харилцагчийн өмчлөлийн ерөнхий бүтцийг тодорхойлж, ойлгох хэрэгтэй. Өмчлөлийн бүтэц нь үргэлжилсэн гинжин хэлхээ бүхий хувьцаа эзэмшлийн бүтэцтэй байх тохиолдолд хувьцаа эзэмшиж байгаа хуулийн этгээд тус бүрийг эрсдэлд суурилсан аргачлалаар шалгаж, харилцагчийн эцсийн үр шимийг хүртэгч хувь хүн тодрох хүртэл эцсийн өмчлөгчийг тодорхойлох ажиллагааг үргэлжлүүлэн хийнэ.

Зураг 1. Өмчлөлийн бүтэц



Зураг 1-д Харилцагч X компанийг Y компани (25%) болон Болд (75%) хамтран өмчилж байна. Y компанийг Дорж, Туяа хоёр 50:50 хувиар хамтран өмчилж байгаа гэж үзье. Энэ тохиолдолд харилцагчийн эцсийн өмчлөгчөөр Болдыг тодорхойлж, мэдээллийг баталгаажуулна. Учир нь Болд нь Компанийн хяналтын багцыг өмчилж байна. Банк шаардлагатай гэж үзвэл Дорж болон Туяа нарын нэмэлт мэдээллийг гаргуулан авч болно. Энэ нь тухайн харилцагчийн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн хийгдэх шаардлагатай.

Зураг 2. Нарийн төвөгтэй өмчлөлийн бүтэц



Зураг 2-т Харилцагч Х компанид ижил тэнцүү хувь эзэмшиж байгаа нийт 5 шууд өмчлөгч байна. Г болон Д компанийг Тулга өмчилж байна гэж үзье. Тэгвэл Тулга нь компанийн 33 хувиас дээш буюу хяналтын багцыг өмчлөгч тул түүнийг эцсийн өмчлөгчөөр тодорхойлж, шаардлагатай мэдээллийг баталгаажуулна.

Хувьцаа эзэмшигчид нь хоорондоо хамаарал бүхий этгээд буюу гэр бүлийн гишүүд байгаа эсэхийг шалгана. Гэр бүлийн нэг гишүүний эзэмшиж байгаа хувийг гэр бүлийн бусад гишүүдийн эзэмшиж байгаа хувьтай нэгтгэж үзэн, нийлбэр дүн нь 33 хувиас дээш байх тохиолдолд эдгээр гэр бүлийн гишүүд тус бүр хэдэн хувийг эзэмшиж байгаагаас үл хамааран эцсийн өмчлөгчөөр тодорхойлно.

Хэрэв хуулийн этгээдийн өмчлөлд хяналтын багцыг буюу 33 хувиас дээш хувийг эзэмшигч этгээд байхгүй (өөрөөр хэлбэл олон өмчлөгчид бүгд бага хэмжээний хувь эзэмшиж буй) тохиолдолд хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, ашиг шимийг хүртгэгч хувь хүнийг олж тогтоон эцсийн өмчлөгчөөр тодорхойлж, шаардлагатай мэдээллийг баталгаажуулна.

Хөрөнгийн бирж дээр нээлттэй хувьцаа нь арилжаалагддаг компанийн хувьцаа эзэмшигчдийн буюу эцсийн өмчлөгчийн мэдээлэл нь гадаадын болон дотоодын хөрөнгийн


биржид бүртгэлтэй бөгөөд нийтэд ил тод мэдээлдэг бол эцсийн өмчлөгчийг тухайн албан ёсны эх сурвалжийг ашиглан тодорхойлж болно.

Хэрэв тухайн хуулийн этгээдийн 33 хувиас дээш хувьцааг эзэмшиж буй этгээд байхгүй бол гүйцэтгэх удирдлагын менежмент, засаглалын тогтолцооны талаарх мэдээллийг гаргуулж авна. Ингэснээр харилцагчийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэгч этгээд хэн болохыг ойлгож, мэдэх боломж бүрдэнэ. Харилцагчийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэгч хувь хүн олдохгүй бол дараах шалгуурыг харгалзан үзэж болно. Үүнд:

- харилцагчийн дээд шатны удирдлагыг томилох, чөлөөлөх, удирдах эрхтэй хувь хүмүүсийг тодорхойлох (тухайлбал ТУЗ, Удирдах зөвлөл гм.)
- дээд шатны удирдлагыг хэрэгжүүлэгч албан тушаалтан хувь хүн (тухайлбал гүйцэтгэх захирал, ерөнхийлөгч),
- харилцагчийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрх бүхий итгэмжлэгдсэн хүн
- хэрэв эцсийн өмчлөгчийг тодорхойлох боломжгүй болсон, мухардалд орсон тохиолдолд үндэслэл бүхий тайлбарын хамт харилцагчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн тодорхойлж, баталгаажуулсан хувь хүн.

Удирдан чиглүүлэгч этгээдийг тогтоох зорилгоор дээрх шалгуурыг ямар ч хэлбэрээр ашиглаж болох бөгөөд харилцагчийн удирдлага, засаглалын бүтцийг ойлгож, дээрх мэдээллийг авсны үндсэн дээр удирдан чиглүүлэгч этгээдийг тогтооно.


Зураг 3. Удирдан чиглүүлэгч этгээд



Зураг 3-т Харилцагч Х компанийг Туяа болон Болд хамтран өмчилж байгаа боловч Туяа нь шийдвэр гаргах бүх саналын эрхийг авсан бөгөөд Болд нь үйл ажиллагааны удирдлагын шийдвэр гаргах эрхийг эдэлж байгаа тохиолдолд Туяа, Болд хоёулаа удирдан чиглүүлэгч буюу эцсийн өмчлөгч этгээд болно.

Түүнчлэн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан эцсийн өмчлөгчтэй холбоотой гарын авлагад дурдсанаар дараах аргуудаар эцсийн өмчлөгчийг тодорхойлдог байна.


1. Каскадын тест /Cascading test/



2. Босго дүн ашиглах /Using threshold/

Зураг 2-т заасан жишээтэй адилаар компанийг шууд болон шууд бусаар өмчилж байгаа этгээдийг олох шаардлагатай.

Америкийн Нэгдсэн Улсын Санхүүгийн мэдээллийн алба буюу Финсен-ээс гаргасан зөвлөмжид эцсийн өмчлөгчийг дараах аргачлалаар тодорхойлно. Үүнд:



Дээр дурдсан аргачлалуудаас гадна тухайн хуулийн этгээдийн жинхэнэ эцсийн өмчлөгчийг тогтооходоо мөн чанарт нь суурилан тогтоож болно. Тухайлбал, тухайн компани нь нэрлэсэн хувьцаа эзэмшигч эсвэл захиралтай бол тус этгээдийг эцсийн өмчлөгчөөр бүртгэхээс гадна тухайн хуулийн этгээдийг цаана нь хэн удирдан чиглүүлж байгааг олох хэрэгтэй.

3.2.Компаниас бусад хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тогтоох нь

- Төрийн бус байгууллага, Шашны байгууллага, Сан, Үйлдвэрчний эвлэл, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг ашгийн бус байгууллагын эцсийн өмчлөгчийг тодорхойлохдоо тухайн байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, зохион байгуулах, гол шийдвэрийг гаргах эрх бүхий дор дурдсан хүнийг тодорхойлно. Үүнд:
 - Удирдах зөвлөлийн дарга, удирдах зөвлөлийн гишүүн,
 - Дээрх этгээд байхгүй бол гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн
 - Дээрх этгээд байхгүй бол үүсгэн байгуулагч хувь хүн
 - Үүсгэн байгуулагч нь өөр нэг хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн төрлөөс хамаарч энэхүү зааварчилгааны дагуу эцсийн өмчлөгчийг хувь хүн хүртэл тогтооно.
- Нөхөрлөлийн (Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл) хувьд эцсийн өмчлөгч нь тухайн нөхөрлөлийн саналын эрхийн дийлэнхийг эзэмшиж байгаа гишүүд, эсвэл нөхөрлөлийн гэрээнд заасны дагуу удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүдийг эцсийн өмчлөгчөөр тооцно.
- Хоршоо болон Хадгаламж зээлийн хоршооны хувьд эцсийн өмчлөгч нь тухайн хуулийн этгээдийн тэргүүлэгчид, дарга, гүйцэтгэх захирал, эсхүл эдгээр удирдах түвшний этгээд байхгүй бол 33 хувиас дээш хувийг эзэмшиж буй хоршооны гишүүдийг эцсийн өмчлөгчөөр тодорхойлно.
- Гадаад улсад бүртгэлтэй болон дотоодын хөрөнгө оруулалтын сангийн 33 хувиас дээш хөрөнгийг оруулсан хувь хүнийг эцсийн өмчлөгчөөр тодорхойлно. Тус этгээдийг тогтоох боломжгүй бол сангийн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал эсвэл сангийн үйл ажиллагааг хянах, удирдах, гол шийдвэрийг гаргах эрх бүхий хувь хүнийг эцсийн өмчлөгчөөр тодорхойлно. Хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлага дор үйл ажиллагаа явуулж байгаа бол тухайн хөрөнгө оруулалтын менежментийн 33 хувиас дээш хувьцааг эзэмшиж буй хувь хүнийг эцсийн өмчлөгчөөр тодорхойлно.
- Олон улсын байгууллагын хувьд Монгол улсад байгуулагдсан суурин төлөөлөгчийн газрын суурин төлөөлөгч эсвэл удирдах эрх бүхий албан тушаалтан, хэрэв суурин төлөөлөгчийн газар байхгүй тохиолдолд тус байгууллагыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан эцсийн өмчлөгч байна.
- Траст буюу гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэгчийн эцсийн өмчлөгчийг тогтоохдоо тухайн трастыг шууд болон шууд бусаар удирдаж байгаа эсхүл ашиг шимийг хүртэгч этгээдийг тодорхойлох шаардлагатай. Үүнд: сетлор, трастий, хамгаалагч (хэрэв байгаа бол), үр шим хүртэгчийн талаар үнэн зөв бодитой мэдээллийг тодорхойлох.

3.3. Өөр хүний өмнөөс гүйлгээ хийж байгаа этгээдийн эцсийн өмчлөгчийг тогтоох нь

Өөр хүний өмнөөс түүнийг төлөөлөн гүйлгээ хийх, данс нээхээр ирсэн этгээдийн эцсийн өмчлөгчийг тогтоогдох боломжтой бөгөөд ийм харилцагч маш олон тохиолддог. Энэ тохиолдолд тухайн данс нээлгэх болон гүйлгээг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж буй жинхэнэ цаад эзэн нь хэн бэ гэдгийг заавал тодорхойлно.

Тухайлбал, мэдээлэх үүрэгтэй этгээд дээр А хүн Б этгээдийн өмнөөс гүйлгээг хийхээр ирсэн гэж үзвэл А болон Б-г бусад эцсийн өмчлөгчийн мэдээлэлтэй тулган үзэж, тэдгээрийн мэдээллийг баталгаажуулна.

Хөрөнгийг удирдах хэлцлийн үндсэн дээр харилцагчийн нэрийн өмнөөс түүнийг хөрөнгийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах эрхтэй этгээд (хуульч, нотариатч, үл хөдлөх хөрөнгийн зуучлагч гэх мэт) төлөөлж буй тохиолдолд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж буй хүнийг заавал тодорхойлно.

Хэрэв мэдээлэх үүрэгтэй этгээд нь данс нээж бизнесийн харилцаа тогтоохоос өмнө нэг удаагийн шинжтэй тохиолдлын гүйлгээ хийх үед тухайн гүйлгээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэж байгаа тохиолдолд нэг удаагийн харилцагч гэдгээс үл хамааран харилцагч болон эцсийн өмчлөгчийг хэн болохыг тогтоож, баталгаажуулах арга хэмжээг авдаг байх шаардлагатай.

3.4. Улс төрд нөлөө бүхий этгээд болон бусад өндөр эрсдэлтэй харилцагч

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч нь улс төрд нөлөө бүхий этгээд эсвэл бусад өндөр эрсдэлтэй харилцагч бол харилцагчийг таньж мэдэх нарийвчилсан арга хэмжээ авна. Хувьцаа эзэмшигч нь улс төрд нөлөө бүхий этгээд бол эзэмшлийн хувь хэмжээ харгалзахгүйгээр эцсийн өмчлөгч гэж үзнэ.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс болон дотоодын эрх бүхий байгууллагаас тодорхойлсон террорист этгээд болон санхүүгийн хориг арга хэмжээний жагсаалтад орсон иргэн хуулийн этгээдтэй харилцаа тогтоож бизнесийн харилцаа үүсгэхийг хориглосон байдаг. Энэ нь ялангуяа банк, санхүүгийн байгууллагын нэр хүндийн эрсдэлд ихээхэн нөлөөлөх учраас ийм харилцагч эцсийн өмчлөгч байдлаар мэдээлэх үүрэгтэй этгээдийн харилцагч болохоос сэргийлэх, энэ төрлийн эрсдэлийг удирдах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

Дээрх шаардлагуудыг биелүүлэх үүднээс харилцагчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох явцад зөвхөн 33 хувиас дээш хувь эзэмшигчдийг тогтоохоос гадна үүнээс бага хувийн хувьцаа эзэмшигч этгээд болон хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдан чиглүүлж, ашиг шимийг хүртэгч бусад этгээд байгаа эсэхийг анхааран шалган үзэх шаардлагатай.

ДӨРӨВ.ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ ТОДОРХОЙЛОХ БОЛОН БАТАЛГААЖУУЛАХ

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлж, мэдээллийг шалган баталгаажуулах боломжит бүхий л арга хэмжээг авах үйл ажиллагааг дотоод бодлого журамдаа тусган, системтэйгээр хэрэгжүүлэх үүрэгтэй. ФАТФ-ын зөвлөмж 10 болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.4-т заасны дагуу шаардлагатай мэдээллийг аваагүй, эсвэл авсан мэдээлэл нь харилцагчийг тодорхойлох болон мэдээллийг баталгаажуулахад хангалтгүй гэж үзвэл бизнесийн харилцаа үүсгэхгүй байх үүрэгтэй.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийн, түүнийг төлөөлж буй этгээд болон эцсийн өмчлөгчийг тодорхойлж, мэдээллийг баталгаажуулах үүрэгтэй. Ингэхдээ албан ёсны найдвартай эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн холбогдох бичиг баримт, мэдээ, мэдээллийг баталгаажуулна.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчаар тусгайлан бэлтгэсэн эцсийн өмчлөгчийг мэдүүлэх маягтыг бөглүүлэн авах замаар эцсийн өмчлөгчийн мэдээллийг тодорхойлон авч болно. Эдгээр мэдээлэл үнэн зөв эсэхийг нягтлаагүй тохиолдолд зөвхөн энэ мэдээлэлд тулгуурлан цаашдын бизнесийн харилцааг үргэлжлүүлж нь эрсдэлтэй.

Харилцагчаас гаргуулан авсан албан ёсны бичиг баримтад үндэслэн баталгаажуулалт хийхээс гадна бусад

төрийн албан ёсны нээлттэй эх сурвалж, мэдээллийн санг ашиглан харилцагчийн эцсийн өмчлөгчийг тогтоож мэдээллийг баталгаажуулах боломжтой. Ийм тохиолдолд тухайн мэдээллийн эх сурвалж нь мэдээлэх үүрэгтэй этгээдийн дотоод бодлого, журам, харилцагчийн эрсдэлийн түвшинд нийцсэн зохистой шаардлагыг хангасан байх шаардлагатай.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь тодорхойлсон эцсийн өмчлөгчийн мэдээллийг баталгаажуулах зорилгоор дараах албан ёсны бичиг баримт, мэдээллийн эх үүсвэрийн аль тохирохыг ашиглан баталгаажуулалт хийж болно. Үүнд тухайлбал:

- Хуулийн этгээдийн гэрчилгээ, дүрэм;
- Хувьцаа эзэмшигчдийн гэрээ;
- Нөхөрлөлийн гэрээ;
- Трастын гэрээ;
- Хуулийн этгээдийн дээд удирдлага, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл;
- Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ;
- Хуулийн этгээдийн санхүүгийн тайлан;
- Улсын бүртгэлийн ерөнхий газраас олгосон лавлагаа;
- Хөрөнгийн биржийн нээлттэй мэдээлэл;
- Эцсийн өмчлөгч хувь хүн тус бүрийн иргэний үнэмлэх, гадаад паспорт эсхүл түүнтэй адилтгах

бусад биеийн байцаалт, баримт бичиг;

- Гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох, баталгаажуулах зорилгоор гадаад улсаас ирүүлсэн бичиг баримтын хүчинтэй байдлыг хангах зорилгоор нотариатаар баталгаажуулах, апостилоор гэрчлүүлэх шаардлага тавьж болох боловч үүнийг эрсдэлд суурилсан аргачлалаар хэрэгжүүлэх;
- Найдвартай, албан ёсны, хараат бус мэдээллийн бусад эх үүсвэр.

Дээр дурдсан биет бичиг баримтаас гадна төрийн албан ёсны мэдээллийн нээлттэй нэгдсэн сан болон хөрөнгийн биржийн ил тод бүртгэлийн санг ашиглан цахимаар лавлагаа авах байдлаар эцсийн өмчлөгчийг тодорхойлох, баталгаажуулах арга хэмжээ авч болно. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг биет болон цахим эх үүсвэрийг ашиглан тодорхойлж, баталгаажуулж болох боловч харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны дагуу харилцагчаас заавал бүрдүүлж авч, хадгалах бичиг баримтуудыг гаргуулан авсан байхыг шаардана.

Харилцагчийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг тогтоох, баталгаажуулах үйл ажиллагааг эрсдэлд суурилсан байдлаар хийнэ. Тухайлбал, харилцагчийн эцсийн өмчлөгч тодроогүй, харилцагчийг таньж мэдэх ажиллагааг бүрэн хийгээгүй, мэдээлэх үүрэгтэй этгээд нь ямар харилцагчтай харилцаж байгаагаа мэдэхгүйгээр харилцагчаар бүртгэх,

бизнес харилцаа тогтоох, өндөр дүнтэй гүйлгээ хийх, үйлчилгээ үзүүлж болохгүй.

Эцсийн өмчлөгчийг тогтоох, баталгаажуулах, тодорхойлох боломжит бүх арга хэмжээг авах шаардлагатай бөгөөд харилцагчийн талаар тодорхой мэдээлэлтэй болсны үндсэн дээр эрсдэлгүй гэж үзвэл үйлчилгээг үзүүлнэ.

4.1. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг тодорхойлох эсхүл баталгаажуулах боломжгүй тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээ

а) Харилцагчийн мэдээллийг нөхөж баталгаажуулах

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ үр дүнтэй удирдаж байгаа бол хууль ёсны бизнес эрхлэгчид болон харилцагчдыг хохироохгүй байх үүднээс эсхүл бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах шаардлагатай байгаа тохиолдолд эцсийн өмчлөгчийг тогтоох, баталгаажуулах ажиллагааг харилцаа тогтоож, үйлчилгээ үзүүлсний дараа хэрэгжүүлж болох нөхцөлийг дотоод бодлого журамдаа тусгаж болно. Жишээ нь: харилцагчийн эцсийн өмчлөгч тогтоогдохгүй, маш нарийн төвөгтэй өмчлөлийн бүтэцтэй бөгөөд харилцагчийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг авахад цаг хугацаа их шаардагдах эсвэл авах боломжгүй тохиолдол гардаг. Ийм үед тухайн харилцагчаас үүсэх эрсдэлийг үнэлэх, удирдах тогтолцоог мэдээлэх үүрэгтэй этгээд бий болгох шаардлагатай. Тухайлбал харилцагчийн гүйлгээний тоо,

дүн, бүтээгдэхүүн үйлчилгээ, харилцааны төрөл зэрэгт хязгаар тогтоох, тусгайлан хяналт тавих зэрэг. Хэрэв эрсдэлийн түвшин хэт өндөр байна гэж үзвэл үйлчилгээ үзүүлэхээс татгалзах зэргээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах арга хэмжээг агуулсан дотоод бодлого, журмыг боловсруулж, хэрэгжүүлдэг байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл эцсийн өмчлөгч тогтоогдоогүй ч гэсэн харилцагчийн үйл ажиллагаа, хийгдэж байгаа гүйлгээ, харилцаанаас үүсэх эрсдэлийг удирдах, учирч болох эрсдэлээс сэргийлэх, мэдээллийг бүрэн авч баталгаажуулах хүртэл харилцааг зохистой хяналтад байгааг нягтлах шаардлагатай.

б) Бизнесийн харилцааг зогсоох, таслах

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчид данс нээж, бизнес харилцаа тогтоосны дараа бизнесийн харилцааны туршид харилцагчийн мэдээллийг тогтмол шинэчлэх, эцсийн өмчлөгчийн мэдээлэлд өөрчлөлт орсон эсэхэд хяналт тавьж бүрэн баталгаажуулах арга хэмжээг авах үүрэгтэй. Хэрэв, харилцагч мэдээллээ шинэчлээгүй эсхүл эцсийн өмчлөгчийн

мэдээлэл хангалтгүй тогтоогдсон гэж үзвэл мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийн данс болон гүйлгээнд хязгаарлалт хийж мэдээллийг зохих түвшинд бүрдүүлсний дараа үйлчилгээ үзүүлэх, эсвэл дансыг хааж, бизнес харилцааг цуцлах хүртэл арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

с) Сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэх

Хэрэв харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хийж гүйцэтгэхэд харилцагчийн зүгээс хүндрэл үүсэх, харилцагч шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзах, мэдээлэх үүрэгтэй этгээдийн харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг харилцагчаас шалтгаалан хийх боломжгүй байгаа эсвэл эцсийн өмчлөгч нь аливаа байдлаар мөнгө угаах болон санхүүгийн гэмт хэрэгтэй холбоотой гэдгээ нуун далдлах зорилготой байж болзошгүй гэж сэжиглэж байгаа тохиолдолд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.4-т заасны дагуу үйлчилгээ үзүүлэхээс татгалзахаас гадна, үйлдлийг сэжигтэй гэж үзвэл Сэжигтэй гүйлгээний тайлангаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.

ТАВ. БУСАД

5.1. Бусад шаардлага

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т заасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох зорилгоор авсан арга хэмжээтэй холбоотой мэдээллийг таваас доошгүй жил хадгалах үүрэгтэй.

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь эцсийн өмчлөгчийг тодорхойлох арга хэмжээг бизнесийн харилцаа тогтоохдоо авч хэрэгжүүлэх ба бизнесийн харилцааны явцад тодорхой хугацааны давтамжтай шинэчлэх арга хэмжээг авна.

5.2. Хяналт шалгалт, зөрчилд тооцох хариуцлага

Мэдээлэх үүрэгтэй этгээдийн эцсийн өмчлөгчтэй холбоотой үүргийн хэрэгжилтэд холбогдох эрх бүхий байгууллага хяналт шалгалт хийж, хуульд заасан шаардлагатай арга хэмжээг авна.

Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу эцсийн өмчлөгчийг тогтоох талаар хуульд заасан зохицуулалтыг зөрчсөн бол зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

ЗУРГАА. ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧТЭЙ ХОЛБООТОЙ МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЖ БАЙЖ БОЛЗОШГҮЙ ШИНЖ ТЭМДГҮҮД

I. Харилцагчтай холбоотой шинж тэмдгүүд:

1. Харилцагч хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаар мэдээлэл өгөхөөс татгалзах, эсвэл худал, зөрчилтэй, төөрөгдүүлсэн, буруу ташаа мэдээлэл өгөх
2. Харилцагч нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч эсвэл хяналтыг багцыг эзэмшиж байгаа этгээдийг тодорхойлоход хэцүү бүтэц зохион байгуулалттай байх
3. Харилцагч доорх мэдээллийг тайлбарлах дургүй эсвэл тайлбарлаж чадахгүй байх:
 - Бизнесийн үйл ажиллагаа, бизнесийн түүх
 - Эцсийн өмчлөгчийн мэдээлэл
 - Хөрөнгийн эх үүсвэр
 - Хэнтэй гүйлгээ хийх гэж байгаагаа
 - Гуравдагч этгээд (ялангуяа гадаад улсад байгаа гуравдагч этгээд)-тэй хийж байгаа бизнесийн мөн чанар
4. Хувь хүн, холбогдох хүмүүс нь:
 - Хангалттай үндэслэлгүйгээр бүх харилцаандаа мэргэжлийн болон мэргэжлийн бус зуучлагч ашиглах
 - Улс төрд нөлөө бүхий этгээд болон тэдний гэр бүлийн гишүүдтэй холбоотой байх
 - Харилцагчийн профайлтай нийцэхгүй гүйлгээ хийх
 - Өмнө нь залилан, татвараас зайлсхийх, гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэл эдэлж байсан
 - Мөрдөн байцаалтын шатанд байгаа эсвэл гэмт хэрэгтнүүдтэй холбоотой
 - Хангалттай тайлбаргүйгээр компанийн дансаар гүйлгээ хийх гарын үсэг зурах эрхтэй хүнээр бүртгүүлсэн байх
5. Хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалттай хуулийн этгээд нь:
 - Үүсгэн байгуулагдсаны дараа удаан хугацааны туршид идэвхтэй үйл ажиллагаа явуулахгүй байж байгаад гэнэт санхүүгийн үйл ажиллагааг нь огцом нэмэгдсэнийг тайлбарлаж чадахгүй байх
 - Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн мэдээллийн сүлжээгээр тус хуулийн этгээдийн талаарх мэдээлэл олдохгүй байх
 - Бусад компани, тэр дундаа томоохон үндэстэй дамнасан корпорацуудын нэртэй адилхан нэртэй байх
 - Ердийн бус имэйл хаягтай байх
 - Компанийн профайлтай нийцгүй хаяг бүртгүүлсэн байх
 - Өөр компанийн хаяг ашиглах
 - Захирал болон хувьцаа эзэмшигчдийн байршлыг тогтоох, холбогдох боломжгүй байх

- Захирал болон хувьцаа эзэмшигчдэд нь тус компанид идэвхтэй үүрэг гүйцэтгэдэггүй байх
 - Захирал, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч нар нь өөр бусад хуулийн этгээдийн дансанд бүртгэлтэй байх
 - Ердийн бус маш олон тооны эцсийн өмчлөгчтэй байх
 - Хангалттай тайлбаргүйгээр тухайн хуулийн этгээдийн дансаар гүйлгээ хийх эрхтэй олон хүмүүсийг бүртгүүлэх
 - Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдсон улс орнуудад үүсгэн байгуулагдсан байх
 - Татварын хувь хэмжээ багатай улс оронд үүсгэн байгуулагдсан байх
 - Цөөн тооны хүлээн авагчтай цөөн тооны өндөр дүнтэй гүйлгээ хийх
 - Хангалттай үндэслэлгүйгээр олон улсын компаниудтай тогтмол гүйлгээ хийх
 - Эцсийн өмчлөгчийг заавал бүртгэдэггүй улс орнуудад үүсгэн байгуулагдсан байх
6. Хувь хүн, хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалттай этгээд нь:
- Гадаад улсын мэргэжлийн зуучлагчдад ойр ойрхон төлбөр шилжүүлэх
 - Хангалттай тайлбаргүйгээр олон банкны данс ашиглах
 - Хангалттай тайлбаргүйгээр гүйлгээг хурдан хийхийг хүсэх
 - Бизнесийн хангалттай үндэслэлгүйгээр компанийн нарийн төвөгтэй бүтцийг үүсгэх
 - Татварын албанд зөв бичиг баримтыг бүрдүүлж өгөөгүй байх
 - Хуурамч бүртгэл, хуурамч бичиг баримт бүрдүүлэх

II. Халхавч компанитай холбоотой шинж тэмдгүүд:

- Зөвхөн нэг ажилтантай эсвэл ажилтангүй байх
- Төлөх ёстой татвар, хураамжийг төлдөггүй байх
- Бодитоор оршин байдаг хаяггүй байх
- Бизнесийн идэвхтэй үйл ажиллагаагүй байх

III. Гүйлгээтэй холбоотой шинж тэмдгүүд:

- Бизнесийн хангалттай үндэслэлгүйгээр хоёр ба түүнээс дээш талуудтай харилцах
- Өндөр үнэтэй бараа бүтээгдэхүүний гүйлгээг бэлэн мөнгөөр хийх
- Хангалттай үндэслэлгүйгээр их хэмжээний зээлийг хугацаанаас нь өмнө төлж дуусгах
- Өмнө нь хийдэг байсан гүйлгээний дүнгээс хэт өндөр дүнтэй гүйлгээ хийх
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдсон улс орон руу гүйлгээ байнга хийх

ДОЛОО. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Албан ёсны нэрлэсэн хувьцаа эзэмшигч болон удирдлага	Зарим улс оронд компанийн хувьцааг төлөөлөл бүхий этгээдийн нэр дээр эзэмшүүлэх, мөн төлөөлөл бүхий удирдлагатай байх боломжийг хуульчилж өгсөн байдаг. Хуулийн этгээдийн энэхүү нэрлэсэн эзэмшигч эсхүл удирдлага нь жинхэнэ эцсийн өмчлөгч, удирдлага нь биш байдаг бөгөөд эцсийн өмчлөгчийн нэрийг нийтэд ил гаргахгүй, нуун далдлах зорилгоор тэдний ойр дотнын гэр бүлийн гишүүд гэх мэт төлөөлж байгаа хувь хүмүүс байдаг.
Эзэмшигчийн хувьцаа ба эзэмшигчийн хувьцааны баталгаа	Эзэмшигчийн хувьцаа, эзэмшигчийн хувьцааны баталгаанд хуулийн этгээдийн өмчлөгч нь хувьцаа эзэмшигчийн сертификатыг эзэмшиж байгаа этгээд нь өмчлөгч болдог тохиролцооны арга хэрэгслүүд орно.
Компани	Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ. Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани гэсэн хэлбэртэй байна.
Мэдээллийн эх сурвалж	Мэдээллийн эх сурвалжид бичиг баримт, тоон мэдээ, мэдээллийн найдвартай, хараат бус эх сурвалжийг хэлнэ.
Мэдээлэх үүрэгтэй этгээд	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т заасан этгээдүүдийг хэлнэ.
Нөхөрлөл	Нөхөрлөл гэдэг нь гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ энэхүү эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөрөө хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээд юм.
Сетлор	Сетлор гэдэг нь итгэмжлэлийн гэрээслэл эсвэл үүнтэй төстэй бусад зохицуулалтаар өөрийн хөрөнгийн эзэмшлийг итгэл хүлээгчид шилжүүлж буй хувь хүн эсвэл хуулийн этгээд юм.
Төрийн бус байгууллага	Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу 1/"төрийн бус байгууллага" гэж иргэд, төрийн байгууллага / хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг; 2/"нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага" гэж соёл, урлаг, боловсрол, хүмүүжил, шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт, байгаль орчин, орчин ахуйн хөгжил, хүний эрх, хүн амын тодорхой бүлэг, давхаргын эрх ашгийг хамгаалах, энэрлийн зэрэг чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг; 3/"гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага" гэж өөрийн гишүүдэд үйлчилдэг, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой, нийгэмд үйлчилдэгээс бусад төрийн бус байгууллагыг.

Төрийн мэдээллийн нэгдсэн сан	Төрийн мэдээллийн нэгдсэн сан гэдэгт УБЕГ-ын www.burtgel.gov.mn , "И-Монголиа төслийн албан ёсны цахим хуудас https://e-mongolia.mn/home , ХУР, ДАН төрийн мэдээлэл солилцооны систем зэргийг хамруулан ойлгоно.
Траст болон үүнтэй төстэй бусад хуулийн этгээд	Траст болон трастын үйлчилгээ үзүүлэгч гэдэг нь компанийн захирал, нарийн бичгийн дарга эсхүл түүнтэй адил албан тушаалд байгаа хүн бүртгэлтэй хуулийн этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллахыг хэлнэ.
Трастий /Итгэл хүлээгч/	Траст гэрээгээр хөрөнгийг захиран зарцуулж байгаа этгээд эсхүл хэд хэдэн этгээдийг хэлнэ.
Улс төрд нөлөө бүхий этгээд	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг хэлнэ.
Үр шим хүртэгч	<p>Үр шим хүртэгч гэдэг нь ФАТФ-ын зөвлөмжид авч үзэж буй асуудлаасаа хамааран өөр өөр утга санаа илэрхийлдэг.</p> <ul style="list-style-type: none"> - Итгэлцлийн хуулиар итгэлцлээс ашиг хүртэгч хувь хүн, этгээдийг үр шим хүртэгч гэдэг. Үр шим хүртэгч нь хувь хүн, хуулийн этгээд, бусад эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд байж болно. Бүх итгэлцлүүд нь (хандивын эсвэл хуулиар зөвшөөрөгдсөн хандивын бус итгэлцлүүд) тодорхой үр шим хүртэгч нартай байх шаардлагатай. Итгэлцлүүд нь заавал тодорхойлж болох эцсийн үр шим хүртэгчтэй байх шаардлагатай ч зарим итгэлцлүүд нь тодорхой этгээдэд үр шим хүртэх эрх үүстэл зөвхөн удирдлагыг хэрэгжүүлдэг эсвэл хөрөнгийг заасан хугацаа (хуримтлалын үе гэдэг) болтол өөр хүн хариуцаж болдог. Энэхүү хугацааг итгэлцлийн байнгын хүчинтэй нөхцөлөөс хамааран уртасгаж болдог бөгөөд үүнийг ихэвчлэн итгэлцлийн гэрээслэлд дурдсан байдаг. - Амь насны даатгал эсвэл бусад хэлбэрийн хөрөнгө оруулалттай холбоотой даатгалын бүтээгдэхүүний хувьд үр шим хүртэгч нь даатгалын тохиолдол учирсан үед тухайн даатгалын нөхөн төлбөрийг хүлээн авдаг хувь хүн, хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээд, хүмүүсийн бүлэг байна. - Мөн Төрийн бус байгууллагаас хандивын, хүмүүнлэгийн эсвэл бусад төрлийн тусламж дэмжлэг хүлээж авдаг хувь хүн эсвэл бүлэг этгээдийг хэлнэ. - Гуйвуулгыг шилжүүлэгч этгээд цахим мөнгөн гуйвуулгын хүлээн авагч хэмээн тодорхойлсон хувь хүн, хуулийн этгээд болон эрх зүйн бусад зохицуулалт бүхий этгээдийг мөн үр шим хүртэгч гэнэ.
Халхавч компани	Хууль бус үйл ажиллагаа, орлогын эх үүсвэрийг хууль ёсны бизнесийн үйл ажиллагаагаар өнгөлөн далдалсан компанийг ойлгоно. Мөн хэд хэдэн улс орон дамнасан бүтэцтэй, гадаадын өмчлөлтэй байх нь элбэг байдаг.

Хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд	<p>Хоригийн жагсаалтад орсон хувь хүн, хуулийн этгээд гэдэгт жишээлбэл:</p> <ul style="list-style-type: none"> - Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн 1267 (1999) тогтоолын дагуу байгуулагдсан хороо (цаашид 1267-ийн Хороо гэх) Аль Кайда бүлэгтэй холбоотой хувь хүн эсвэл түүнтэй холбоотой бүлэг, байгууллага, аж ахуйн нэгжүүд. - Аюулгүйн зөвлөлийн 1988 (2011) тогтоолын (цаашид 1988-ийн Хороо гэх) дагуу байгуулагдсан хорооны тодорхойлсон Афганистаны энх тайван, тогтвортой байдал, аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй Талибан бүлэгтэй холбоотой хувь хүн эсвэл түүнтэй холбоотой бүлэг, байгууллага, аж ахуйн нэгжүүд. - Аюулгүйн зөвлөлийн 1373 (2001) тогтоолын дагуу аливаа юрисдикц эсвэл бүс нутгийн юрисдикцийн тодорхойлсон аливаа хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүд. - Аюулгүйн зөвлөлийн 1718 (2006) тогтоол болон түүнтэй холбоотой Аюулгүйн зөвлөлийн дараагийн тогтоол, хавсралтуудад дурдсан болон “Аюулгүйн зөвлөлийн 1718 (2006) тогтоол”-д (цаашид 1718-ийн Хоригийн Хороо гэх) хорооны тодорхойлсон санхүүгийн хориг арга хэмжээ авах шаардлагатай хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүд. - Аюулгүйн зөвлөлийн 1737 (2006) тогтоол болон түүнтэй холбоотой Аюулгүйн зөвлөлийн тогтоол, хавсралтуудад дурдсан эсвэл 1737 тогтоол болон холбогдох тогтоолыг хэрэгжүүлэх “Аюулгүйн зөвлөлийн Хорооны 1737 (2006) дугаар тогтоолын 18 дугаар хэсэг”-ийн дагуу байгуулагдсан хорооны (цаашид 1737-ын Хоригийн хороо гэх) тодорхойлсон санхүүгийн хориг арга хэмжээ авах шаардлагатай хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүд гэх мэт орно.
Хоршоо ба нийгэмлэг	<p>Хоршооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан хамтын, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.</p> <p>3.2.Хоршоод аж ахуйн үйл ажиллагаагаа хамтран эрхлэх зорилгоор бусад хоршоо болон хуулийн этгээдтэй хамтран дундын хоршоо байгуулж болно. Дундын хоршооны гишүүдийн 51-ээс доошгүй хувь нь хоршоо байна</p>

**Хуулийн
этгээд**

Иргэний хуулийн Дөрөвдүгээр бүлгийн 25 дугаар зүйлд заасны дагуу:
25.1.Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.

25.2.Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно.

25.3.Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байна.

ХАВСРАЛТ

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨРЛӨӨР ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ ТОГТООХ ЖИШИГ¹:

№	Хуулийн этгээдийн төрөл	Эцсийн өмчлөгчийг хэрхэн тогтоож болох вэ?
1	Нөхөрлөл	<p>Нөхөрлөл (Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл) хувьд эцсийн өмчлөгч нь тухайн нөхөрлөлийн саналын эрхийн дийлэнхийг эзэмшиж байгаа гишүүд, эсвэл нөхөрлөлийн гэрээнд заасны дагуу удирдах, төлөөлөх эрх бүхий гишүүдийг эцсийн өмчлөгчөөр тооцож болно.</p>
2	Компани	<p>Дараах дэс дарааллын дагуу компанийн эцсийн өмчлөгчийг тодорхойлж болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> a. Компанийн 33 хувиас дээш буюу хяналтын багцыг өмчилж байгаа этгээд; b. (a) этгээд байхгүй бол компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, ашиг шимийг хүртгэгч этгээд; c. Хөрөнгийн биржид бүртгэлтэй, нээлттэйгээр хувьцаа нь арилжаалагддаг, нийтэд ил тод мэдээлдэг бол эцсийн өмчлөгчийг тухайн албан ёсны эх сурвалжийг ашиглан тодорхойлох; d. Компанийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрх бүхий итгэмжлэгдсэн хүн; <p>Хэрэв эцсийн өмчлөгчийг тодорхойлох боломжгүй болсон, мухардалд орсон тохиолдолд үндэслэл бүхий тайлбарын хамт харилцагчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн тодорхойлж, баталгаажуулж өгсөн хувь хүнийг эцсийн өмчлөгчөөр бүртгэж болно.</p>
3	Сан	<p>Хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгө оруулалтын менежментийн компанийн удирдлага доор үйл ажиллагаа явуулж байгаа бол тухайн хөрөнгө оруулалтын менежментийн компанийн 33 хувиас дээш хувьцааг эзэмшиж буй хувь хүнийг эцсийн өмчлөгчөөр тодорхойлж болно.</p>

¹ Энэ хэсэгт хуулийн этгээдийн төрлөөр эцсийн өмчлөгчийг хэрхэн тогтоох талаарх жишээнүүдийг багтаасан бөгөөд эдгээр жишгээс өөрөөр хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг тогтоох боломж байвал өөр арга хэлбэрээр тогтоож болно.

4	Хоршоо	Хоршоо болон хадгаламж зээлийн хоршооны хувьд эцсийн өмчлөгч нь тухайн хуулийн этгээдийн тэргүүлэгчид, дарга, гүйцэтгэх захирал, эсвэл эдгээр удирдах түвшний этгээд байхгүй бол 33 хувиас дээш хувийг эзэмшиж буй хоршооны гишүүдийг эцсийн өмчлөгчөөр тодорхойлж болно.
5	Холбоо /төрийн бус байгууллага/	Төрийн бус байгууллага, Шашны байгууллага, Сан, Үйлдвэрчний эвлэл, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэг ашгийн бус байгууллагын эцсийн өмчлөгчийг тодорхойлохдоо тухайн байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, зохион байгуулах, гол шийдвэрийг гаргах эрх бүхий доор дурдсан хүнийг тодорхойлно. Үүнд:
6	Шашны байгууллага	
7	Нийтийн эрх зүйн хуулийн этгээд / Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуульд зааснаар “нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гэж хуулийн дагуу нийтийн эрх ашгийн төлөө байгуулагдаж, нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн эрх үүргийг хүлээсэн, зохион байгуулалт, үйл ажиллагааг хууль, өөрийн дүрмээр нарийвчлан зохицуулдаг, төрийн зохицуулалт бүхий холбоог хэлнэ. /	<ul style="list-style-type: none"> - Удирдах зөвлөлийн дарга, удирдах зөвлөлийн гишүүн; - Дээрх этгээд байхгүй бол гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн; - Дээрх этгээд байхгүй бол үүсгэн байгуулагч хувь хүн; - Үүсгэн байгуулагч нь өөр нэг хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн төрлөөс хамаарч энэхүү гарын авлагад дурдсаны дагуу эцсийн өмчлөгчийг хувь хүн хүртэл тогтооно.
8	Төрийн байгууллага, албан газар	Хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, удирдан чиглүүлж байгаа хүнийг эцсийн өмчлөгчөөр бүртгэж болно.
9	Улсын төсөвт үйлдвэрийн газар	
10	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	
11	Төрийн өмчит хуулийн этгээд	Олон улсын байгууллагын хувьд Монгол улсад байгуулагдсан суурин төлөөлөгчийн газрын суурин төлөөлөгч эсвэл удирдах эрх бүхий албан тушаалтныг эцсийн өмчлөгчөөр бүртгэж болно. Хэрэв суурин төлөөлөгчийн газар байхгүй тохиолдолд тус байгууллагыг төлөөлөх эрх бүхий
12	Олон улсын байгууллага	

	албан тушаалтан нь эцсийн өмчлөгч нь байж болно.
13 Траст	Траст буюу гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэгчийн эцсийн өмчлөгчийг тогтоохдоо тухайн трастыг шууд болон шууд бусаар удирдаж байгаа эсвэл ашиг шимийг хүртэгч этгээдийг тодорхойлох шаардлагатай болно. Үүнд: сетлор, трастий, хамгаалагч (хэрэв байгаа бол), үр шим хүртэгчийн талаар үнэн зөв бодитой мэдээллийг тодорхойлох шаардлагатай.